



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалт Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр” ХК-ийн 2023 оны сүүлийн хагас жилийн “Си Эс Ай аудит” ХХК-иар баталгаажсан санхүүгийн тайланг хавсралтын дагуу баталсугай.
2. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг “ХАНГАЛТТАЙ САЙН” гэж дүгнэсүгэй. Энэ дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, батлуулахыг ТУЗ-ийн дарга (Д.Оюунсүрэн)-д даалгасугай.
3. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТ
ГЕРМЕСЦЕНТР
ХК
ДАРГА
ТТБ1437-а.2773878
Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 10 дугаар зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Гермес центр" ХК-ийн 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашиг 740 412 667.98 сая төгрөгийн
 - 97.5 %-ийг буюу 722 595 609.2 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар
 - 2.5 %-ийг буюу 17 817 058.78 төгрөгийг компанийн цалин урамшуулал болон нөөцийн санд тус тус хуваарилсугай.
2. "Гермес центр" ХК-ийн 2023 оны сүүлийн хагас жилийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20~~23~~²⁴ оны ~~02~~⁰² сарын ~~14~~¹⁴ өдөр

Дугаар ~~...~~³

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76.1.12-р заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 9 төгрөг 20 мөнгө (ёсөн төгрөг хорин мөн)-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03-р сарын 7-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны сүүлийн хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2024 оны 03-р сарын 15-ны өдрөөс эхлэн компанийн байранд бэлэн мөнгөөр болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-тай гэрээ байгуулан 2024 оны 4-р сарын 15-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг), нягтлан бодогч (О.Энхтуяа) нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар ... 5

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3-р заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01-р сарын 27-ны өдрийн 45 тоот тогтоолоор шинэчлэгдсэн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн 15:00 цагт компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
 - 2.2 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
 - 2.3 Компанийн 2024 оны үйл ажиллагааны зорилтын тухай
 - 2.4 Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2024 оны 03-р сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2024 оны 02-р сарын 16-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг хавсралт 1-р баталж, 2024 оны 02-р сарын 19 болон 2024 оны 03-р сарын 05-ны өдрүүдэд тус тус Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2024 оны 02-р сарын 23-ны өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын энгийн санал авах саналын хуудсыг хавсралт 3-р баталж, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 04-р сарын 04-ний өдрийн 18:00 цаг хүртэл хүлээн авахыг тооллогын комисс (О.Золжаргал)-т үүрэг болгосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэнг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Комиссын дарга: О.Энхтуяа, Нягтлан бодогч
Гишүүн: Д.Эрдэнэсүрэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга: О.Золжаргал
Гишүүд: Г.Мандалцэцэг
Б.Чимэгээ
11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зар мэдээ болон бусад зардлыг компанийн үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргахыг Гүйцэтгэх захирал (Б.Оюунцэцэг)-т зөвшөөрсүгэй.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журмыг мөрдөж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга (Д.Оюунсүрэн), хурал зохион байгуулах комисс (О.Энхтуяа) нарт үүрэг болгосугай.
13. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д үүрэг болгосугай.



Д.ОЮУНСҮРЭН

ГЕРМЕСЦЕНТР
ХК

ТТ54437-2772678

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗАРЛАХ ХЭВЛЭЛИЙН ЭХ

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Гермес центр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн 15:00 цагт тус компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд болох тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна.

Бүртгэлийн өдрийг 2024 оны 03-р сарын 07-ны өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал :

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, диллерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, “Гермес центр”ХК-ийн төв оффисын байрны 3 давхар № 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах:

Комиссын дарга : О.Энхтуяа, утас 9909-4991, имэйл хаяг: enkhee_7777@yahoo.com

Гишүүн : Д.Эрдэнэсүрэн, утас 9908-8571, имэйл хаяг: erdenesuren2213@gmail.com

Зар түгээх мэдээллийн хэрэгслүүдийн жагсаалт:

- Өдрийн сонин
- Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудас
- Өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудас

Зар гаргах өдрүүд : 2024 оны 02-р сарын 19-ны өдөр, 2024 оны 03-р сарын 05-ны өдөр

Жич : Сонинд зарыг гаргахдаа аудитын дүгнэлт болон санхүүгийн хураангуй тайланг хавсаргана.



“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, диллерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, “Гермес центр”ХК-ийн төв оффисын байрны 3 давхар № 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.

Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт

- 1.1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан
- 1.2 Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
- 1.3 Компанийн 2024 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- 1.4 Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийн тухай



"ГЕРМЕС ЦЕНТР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

(Хэлэлцэх асуудал)

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог :

Хувьцаа эзэмшигчийн нэр :

Регистрийн дугаар:

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Брокерийн компанийн нэр :

"Гермес Центр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн 15:00 цагт "Гермес Центр" ХК-ийн төв байранд болно.

Санал авах хуудас ашиглах санамж

Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ

1 нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан эсвэл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.

2 Засварласан, балласан болон залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

3 Хувьцаа эзэмшигч та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харилцдаг брокер дилерийн компани болон "Гермес Центр" ХК-ийн оффисын 3-р давхрын 302 тоот өрөөнд 2024 оны 4-р сарын 04-ний өдрийн 18:00 цагаас өмнө ирүүлнэ үү.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай			

Хувьцаа эзэмшигч (Итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн гарын үсэг:()

Санал авах хуудас үйлдсэн 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тоохон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга:(О.Золжаргал)

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"Гермес Центр"ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам 20, "Гермес Центр" ХК-ийн төв оффисын байр, холбогдох утас: 30-15-77,
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 04-р сарын 05-ны өдөр
Хурал хуралдах газар /хаяг, байршил/ :	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам 20, "Гермес Центр" ХК-ийн төв оффисын байрны 3-р давхарт байрлах хурлын танхимд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдуулах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 02-р сарын 14-ний өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 02-р сарын 19-ний өдөр, 2024 оны 03-р сарын 05-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 03-р сарын 07-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:	2024 оны 02-р сарын 23-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2024 оны 02-р сарын 16-ны өдөр
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын дарга: О.Золжаргал Гишүүд Г.Мандалцэцэг, Б.Чимэгээ
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолууд, бусад хавсралтуудын хамт
Баримт, бичгийн хуудасны тоо:ширхэг
хуудас



УЛААНБААТАР ХОТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

ГЕРМЕСЦЕНТР ХК/О.Энхтуяа/

2024 оны 02-р сарын 16-ны өдөр

ТТБ1437-2773678